

Энэхүү инфографикт Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ) болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ) (2017-2022)-ний бие даасан үнэлээний гол үр дүнг харуулав. Энэ нь 2021 оны 12-р сард гаргасан Үнэлгээний тайланд үндэслэсэн болно. НҮБХТХ (2017-2022)-г Монгол Улсын урт хугацааны стратегийн бодлогын баримт бичиг болох "МУТХҮБ-2030"-тай нийцүүлэн боловсруулсан. НҮБХТХ-нд НҮБ-ын 15 агентлаг гарын үсэг зурсан бөгөөд энэ нь үндэстний хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын системийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээг харуулсан. НҮБХТХ нь дараах үндсэн гурван стратегийн үр дүнгийн чиглэлээр боловсруулагдсан:



Байгалийн нөөцийн хүртээмжтэй өсөлт, тогтвортой менежментийг дэмжих



Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш нийгмийн үйлчилгээг дэлгэрүүлэх



Олон нийтийн дуу хоолой, тайлагнах зарчмыг бэхжүүлэх

## ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО



НҮБ-ын системийн байгууллагууд хариуцлагатай хувь нэмэр оруулсан эсэхийг үнэлэх



Туршлагаасаа суралцахад нь дэмжлэг үзүүлэх

## ГОЛ ҮР ДҮН / САНАЛ ЗӨВЛӨМЖ



### Хамааралтай байдал

- НҮБХТХ нь ТХЗ-2030-уудыг сайн тусгасан "МУТХҮБ-2030"-тай нийцтэй байсныг баримт нотолгоонууд харуулж байна.
- НҮБ нь улс оронд шинээр тулгамдсан, урьдчилан тооцоолоогүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан. Үүний хамгийн тод жишээ бол Ковид-19 цар тахлын эсрэг авч буй НҮБ-ын хамтын хариу арга хэмжээ юм.
- Гэсэн хэдий ч Монгол Улсын Засгийн газар байнга солигдож, нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж, байгууллагын залгамж чанар алдагдаж, НҮБХТХ-ий хэрэгжилтийг хадгалахад бэрхшээл тулгарч байсан.



### Үр дүнтэй байдал

- НҮБХТХ-ний зарим шалгуур үзүүлэлтүүд нь НҮБ-ын хувь нэмрийг үнэлэхэд хэтэрхий өндөр түвшинд буюу амбицтай боловсруулагдсан тул үр дүнтэй хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх боломжгүй байдлаар томъёологдсон байна.
- Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах/үнэлэх боломжтой эсэхэд шинжилгээ хийх дасгал нь үр дүнгийн матрицын үр дүнг илүү сайн хэмжихэд тохирох эсэхийг баталгаажуулахад тустай байх байлаа.
- Өөрчлөлтийн онол нь НҮБ-ын тодорхойлсон үр дүнд хүрэхэд холбогдох завсрын зорилт болох гарцууд хангалттай эсэх мөн тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт нь бүх хувь нэмрийг харуулахад тохиромжтой эсэхийг баталгаажуулахад тустай байх байсан.
- НҮБ дараагийн Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБТХХАХ)-гээ боловсруулахдаа НҮБ-ын хувь нэмрийг нарийн тодорхойлж, үр дүн, гарц нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь үр дүнг хэмжихэд тохиромжтой байдлаар томъёолох шаардлагатай.



### НҮБХТХ-ний үр дүнд оруулсан НҮБ-ын хувь нэмэр

- НҮБХТХ-ний зарим шалгуур үзүүлэлтүүд нь НҮБ-ын хувь нэмрийг үнэлэхэд хэтэрхий өндөр түвшинд буюу амбицтай боловсруулагдсан тул үр дүнтэй хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх боломжгүй байдлаар томъёологдсон байна.
- Шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах/үнэлэх боломжтой эсэхэд шинжилгээ хийх дасгал нь үр дүнгийн матрицын үр дүнг илүү сайн хэмжихэд тохирох эсэхийг баталгаажуулахад тустай байх байлаа.
- Өөрчлөлтийн онол нь НҮБ-ын тодорхойлсон үр дүнд хүрэхэд холбогдох завсрын зорилт болох гарцууд хангалттай эсэх мөн тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт нь бүх хувь нэмрийг харуулахад тохиромжтой эсэхийг баталгаажуулахад тустай байх байсан.
- НҮБ дараагийн Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБТХХАХ)-гээ боловсруулахдаа НҮБ-ын хувь нэмрийг нарийн тодорхойлж, үр дүн, гарц нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь үр дүнг хэмжихэд тохиромжтой байдлаар томъёолох шаардлагатай.



### Тогтвортой байдал

- НҮБХТХ-ний хүрээнд эхлүүлсэн хамтын ажиллагааны төслүүдийг үндэстний түншүүд дэмжих буюу Засгийн газар залгуулан хэрэгжүүлж, өргөжүүлж байгаа олон тодорхой жишээ байна.
- Гэсэн хэдий ч нөөцийн хүрэлцээгүй байдал, цар хүрээг нэмэгдүүлэх эсвэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх стратеги байхгүй байгаа нь тодорхой хугацааны дараа НҮБХТХ-ний үр өгөөжийг бууруулж, цаашид үргэлжлэх боломжийг хязгаарлаж байгаа. Хүүхдэд үзүүлэх нийгмийн

үйлчилгээтэй холбоотой зарим амжилттай НҮБ-ын үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөв байхгүйн улмаас зогссон.

- Хамтын ажиллагааны хүрээг Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, тогтвортой байдлыг хангахын тулд НҮБХТХ-г боловсруулж эхлэх цагаас л Засгийн газар оролцох нь маш чухал.

### Үр нөлөө

- НҮБХТХ хүмүүст бодитой нөлөө үзүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хүний эрх, амьдрах орчныг хамгаалах тал дээр ахиц гаргасан. НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн нийгмийн эрүүл мэндийн олон арга хэмжээ хүмүүст бодитоор хүрсэн.
- НҮБ-ын зарим агентлагуудын үнэлгээний тайланд үр нөлөөний талаар сонирхолтой дүгнэлтүүд бичигдсэн байсан нь НҮБХТХ олон талаар мөн НҮБ-ын агентлагуудын хөтөлбөрөөр бодит үр нөлөөтэй байсныг нотолж байна. Гэхдээ зарим тохиолдолд үр дүнгийн нөлөөг үнэлэхэд хэтэрхий эрт байна.

### НҮБ-ын байгууллагуудын уялдаа холбоо ба зохицуулалт

- Цөөн хэдэн хамтын нэгдсэн хөтөлбөрийг эс тооцвол НҮБХТХ нь НҮБ-ын системийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнтэй, стратегийн хэрэгсэл болж чадаагүй ба эдгээр нь ерөнхийдөө НҮБХТХ-нээс үүдээгүй, санхүүгийн боломжийг ашиглан санхүүжилтэд ихээхэн тулгуурласан хөтөлбөрүүд байсан.
- Гэсэн хэдий ч НҮБХТХ нь НҮБ-ын бүх агентлагт ерөнхий чиглэлийг тогтоож, агентлагууд хоорондоо хэрхэн уялдаж, хамтын нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх том дүр зургийг өгч байсан.
- Алслагдмал, эмзэг бүлгийн хүн амд онцгойлон чиглэсэн хамтын нэгдсэн хөтөлбөр нь НҮБ-ын үйл ажиллагааны газарзүйн тархалтыг илүү нэгдсэн арга замаар шийдвэрлэх боломжтой загвар байж болох бөгөөд тэдгээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өргөжүүлэх боломжтой гэж үнэлгээний багийнхан үзэж байна.

### НҮБ ба түүний түншүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо

- НҮБ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын гол цөм болох ТХЗ-ыг сурталчлан таниулах замаар төрийн байгууллагуудын зохицуулалт, уялдаа холбоог хангахад хувь нэмэр оруулсан.
- Гэсэн хэдий ч НҮБХТХ-ний хэрэгжилтэд хариуцлагатай хандаж ажиллах тал дээр Засгийн газар илүү үүрэгтэй оролцож, хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.
- Суурин зохицуулагч болон НҮБ-ын Удирдлагын баг нь хөгжлийн түншүүдтэй ойр дотно харилцаатай байдаг. Хөгжлийн Түншүүдийн Бүлгийн ажлын даалгаврыг боловсруулах замаар НҮБ болон хөгжлийн түншүүдийн хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах хүчин чармайлт гаргаж байна.

- Нэмж дурдахад, тодорхой нэг салбар чиглэлийн хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үр дүн уялдааг сайжруулахын тулд Суурин зохицуулагчийн манлайлал дор Суурин Зохицуулагчийн газар нь Хөгжлийн Түншүүдийн Бүлгийн дэд/сэдэвчилсэн бүлгүүдийг байгуулах ажлыг зохицуулж байна. Энэ нь эмзэг нарийн асуудлуудаар Засгийн газартай тууштай хэлэлцээр хийж, илүү шийдвэр гаргуулахад дэм өгөх юм. ИНБ-ууд нь НҮБ болон хөгжлийн түншүүдийн аль алинтай нь хамтран ажиллаж чаддаг бөгөөд НҮБХТХ-г хэрэгжүүлэхэд эрдэм шинжилгээний болон хувийн хэвшилтэй хамтран ажиллах боломж бий.

### Удирдлагын тогтолцоо ба шийдвэр гаргалтын үйл явц

- НҮБХТХ-ний Удирдах зөвлөл нь гол гол шийдвэрлэх хэлэлцүүлэгт бага оролцож байсан ба жилд 2 эсвэл 3 удаа тогтмол хуралдаж, гол асуудлуудыг хэлэлцэх нь тэдний оролцоог илүү бодитой болгож, ирээдүйн Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд Засгийн газрын өндөр албан тушаалтнууд эзэн байх боломжийг нэмэгдүүлэх юм.
- Одоогийн НҮБХТХ-ны хэрэгжилтийн явцад Үр дүнгийн болон Сэдэвчилсэн бүлгүүд цөөхөн удаа уулзсан. Үр дүнгийн бүлгүүдийн зохицуулалтад суурин зохицуулагч болон НҮБ-ын Удирдлагын багийн аль алиных нь оролцоо болон үүрэг хязгаарлагдмал байсан. Үр дүнгийн бүлгүүдийг НҮБ-ын агентлагууд болон Засгийн газар хамтран даргалж, (даргалах байгууллагыг 2 жилээр ээлжлэн сонгож болох юм) үр дүнг хянах чухал хэлэлцүүлгүүдэд Засгийн газрын холбогдох талуудыг хамруулах нь зүйтэй гэж үнэлгээний баг үзэж байна. Зөвхөн хангалттай боловсон хүчинтэй, чадавхтай суурин агентлагууд л Үр дүнгийн бүлгийг хамтран даргалах ажлыг хийх боломжтой.

### Хамтарсан ажлын төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, тайлагналт

- НҮБХТХ-ний баримт бичгийг Хамтын нэгдсэн ажлын төлөвлөгөө болон/эсвэл агентлагийн ажлын төлөвлөгөө, төслийн баримт бичгүүдийг боловсруулах замаар хэрэгжүүлдэг байтал НҮБ-ын баг НҮБХТХ-ний хэрэгжилтийг хянахад ашиглах хамтын нэгдсэн ажлын төлөвлөгөөг боловсруулаагүй байна. НҮБХТХ-г хэрэгжүүлэхэд хамтын нэгдсэн ажлын төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай гэж үзээгүй байна.
- Үүний оронд НҮБ-ын агентлагуудын хэрэгжүүлж буй бүх төслүүдийг UN-INFO системд оруулсан. Энэ нь хамтдаа хүрэх үр дүнг системтэй харуулж чадахгүй байгаа юм. Гэсэн хэдий ч Үр дүнгийн бүлгүүд болон Суурин зохицуулагчийн газрын дэмжлэгтэйгээр НҮБ-ын Удирдлагын баг нь UN-INFO-г ашиглан НҮБХТХ-ний үйл ажиллагаа эхэлснээс хойш Монгол Улс дахь НҮБ-ын бүх байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хянаж, шинжлэн үр дүнг маш сайн баримтжуулж нэгтгэн жил бүр тайлагнаж байна.



## Үр ашигтай байдал

- Үйл ажиллагааны удирдлагын баг нь худалдан авах ажиллагааны нийтлэг бизнесийн үйл явцаар дамжуулан илүү хэмнэлт гаргах, үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор нийтлэг бизнесийн үйл ажиллагааг дэвшилтэт болгосон. Нэгдсэн мөнгөн шилжүүлгийн тусламжтайгаар төрийн болон төрийн бус түншүүдэд бэлэн мөнгө шилжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн хүрээгээр дамжуулан гүйлгээний зардлыг бууруулсан. НҮБ-ын шинэчлэлийн үр ашгийн хөтөлбөрийн нэг хэсэг болох арын албаны санаачилгаар цаашид гүйлгээний зардлыг бууруулах боломжтой.



## Хүний эрхэд суурилсан хандлага

- НҮБ нь хүний эрхийн асуудлаар дуу хоолойгоо тууштай илэрхийлдэг байгууллагуудын нэг бөгөөд хүний эрхийн конвенцыг хэрэгжүүлэхэд нь Монгол Улсад дэмжлэг үзүүлдэг. НҮБХТХ-ний хэрэгжилт нь хүний эрхийн асуудалд онцгой анхаарсан бөгөөд Монгол Улс олон улсын болон бүс нутгийн өмнө хүлээсэн амлалт, үүргээ биелүүлэхэд хувь нэмрээ оруулсан.
- Гэсэн хэдий ч одоогийн НҮБХТХ-ний хэрэгжилт нь Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг болон хүний эрхийн бусад механизмын дүгнэлт, зөвлөмжид төдийлөн анхаарал хандуулаагүй. Эдгээр механизмын зүгээс удаа дараа гаргасан дүгнэлт, зөвлөмжийг Засгийн газар авч хэрэгжүүлээгүй байна.
- Хүний эрхийн сэдэвчилсэн бүлэг 2020 оны сүүлээр байгуулагдсан бөгөөд үр дүнгийн бүлгүүдтэй идэвхтэй хамтран ажиллаагүй.
- Хүний эрхэд суурилсан хандлагыг Засгийн газрын бодлогын түвшинд тодорхой тусгаж, буулгаагүй. Мөн ИНБ-ууд иргэний нийгэм өмнөхөөсөө илүү хязгаарлагдмал орон зайтай болж, цар тахлын үед хэрэгжүүлсэн хориглох арга хэмжээнүүд хүний зарим эрхэд заналхийлж байна гэж үзэж байна.



## Хэнийг ч орхигдуулахгүй байх

- НҮБ нь хүний эрхийн асуудлаар дуу хоолойгоо тууштай илэрхийлдэг байгууллагуудын нэг бөгөөд хүний эрхийн конвенцыг хэрэгжүүлэхэд нь Монгол Улсад дэмжлэг үзүүлдэг. НҮБХТХ-ний хэрэгжилт нь хүний эрхийн асуудалд онцгой анхаарсан бөгөөд Монгол Улс олон улсын болон бүс нутгийн өмнө хүлээсэн амлалт, үүргээ биелүүлэхэд хувь нэмрээ оруулсан.
- Гэсэн хэдий ч одоогийн НҮБХТХ-ний хэрэгжилт нь Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг болон хүний эрхийн бусад механизмын дүгнэлт, зөвлөмжид төдийлөн анхаарал хандуулаагүй. Эдгээр механизмын зүгээс удаа дараа гаргасан дүгнэлт, зөвлөмжийг Засгийн газар авч хэрэгжүүлээгүй байна.
- Хүний эрхийн сэдэвчилсэн бүлэг 2020 оны сүүлээр байгуулагдсан бөгөөд үр дүнгийн бүлгүүдтэй идэвхтэй хамтран ажиллаагүй.
- Хүний эрхэд суурилсан хандлагыг Засгийн газрын бодлогын түвшинд тодорхой тусгаж, буулгаагүй. Мөн ИНБ-ууд иргэний нийгэм өмнөхөөсөө илүү хязгаарлагдмал орон зайтай болж, цар тахлын үед хэрэгжүүлсэн хориглох арга хэмжээнүүд хүний зарим эрхэд заналхийлж байна гэж үзэж байна.



## Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

- Жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар НҮБХТХ-ний төсөл боловсруулах явцад болон бүх үр дүнд тусгасан байна. Ялангуяа Үр дүн 3-т түлхүү оруулж өгсөн байна.
- Гэсэн хэдий ч Үр дүнгийн бүлгүүд болон Жендэрийн бүлгийн хооронд амьд холбоо байгаагүй. Жендэрийн бүлэг нь жендэртэй холбоотой асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэж чадна.
- Уг бүлэг нь агентлаг бүрийн онцлог давуу талыг ашиглан эдгээр асуудал дахь НҮБ-ын хамтарсан хариу арга хэмжээг зохион байгуулах боломжтой. Ковид-19 цар тахлын улмаас жендэрийн тэгш бус байдал болон жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх хандлагатай байгаа тул жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийн эрх мэдэлд анхаарал хандуулах хэрэгтэй.
- Мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын ялгаа, жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд эрэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг гэх мэт хүйсийн ялгааг хэлэлцэх үед эрэгтэйчүүдэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

### Тэргүүлэх ач холбогдолтой зөвлөмжүүд:

1. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь дараагийн Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг (НҮБТХХАХ) ТХЗ-д нийцсэн хамтын алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл байдлаар хэрэглэх.
2. Засгийн газар дараагийн НҮБТХХАХ-д эзэн болж, стратегийн удирдлагыг нэмэгдүүлэх.
3. НҮБ-ын агентлагууд НҮБТХХАХ-г хэрэгжүүлэхдээ Үр дүнгийн болон Сэдэвчилсэн бүлгүүдээр дамжуулан хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх мөн тэдгээр бүлгүүдийг ашиглан Суурин зохицуулагчийн манлайлал дор НҮБ-ын Удирдлагын баг ТХХАХ-г стратегийн түвшинд удирдах.
4. НҮБ-ын Удирдлагын баг Суурин зохицуулагчийн манлайлал дор НҮБТХХАХ-ний "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчим, хүний эрхэд суурилсан хандлагыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэх.
5. НҮБ-ын Удирдлагын баг жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх гэх мэт НҮБТХХАХ-ний үндсэн зарчмыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэх.
6. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар дараагийн НҮБТХХАХ-ийн хүрээнд санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бий болгож, 2030 он хүртэлх мөрийн хөтөлбөрийг биелүүлэхэд шаардагдах нөлөөллийн цар хүрээг хангах хангалттай санхүүжилтийн хэрэгслийг бий болгох талаар бодож үзэх.

### Дунд түвшний ач холбогдолтой зөвлөмжүүд:

1. НҮБ-ын Удирдлагын баг НҮБТХХАХ-ний үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн оролцогч талуудтай хамтран үр дүнтэй түншлэл, стратегийн хамтын ажиллагааг дэмжих.
2. НҮБ-ын Удирдлагын багт хамтын нэгдсэн хөтөлбөр боловсруулалтыг нэмэгдүүлэх, зорилтот хамтын нэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй. Ингэхдээ НҮБ-ын үйл ажиллагааны газар зүйн тархац, нэгдсэн хөтөлбөр боловсруулалт, газар зүйн зорилтот байршлын сайн туршлагыг харгалзах.
3. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар НҮБТХХАХ-г стратегийн түвшинд хянаж, удирдахын тулд үр дүнд суурилсан удирдлага, ХШҮ-ний тогтолцооны хэрэглээг нэмэгдүүлэх.
4. НҮБ-ын Удирдлагын баг, Үндэсний статистикийн хороо болон яамд хамтран мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үндэсний чадавхыг сайжруулах хэрэгтэй. Энэ нь ТХЗ, дараагийн НҮБТХХАХ-ний хэрэгжилтийн явцыг хэмжихэд чухал ач холбогдолтой юм.
5. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар НҮБТХХАХ-ийн тогтвортой байдлыг бэхжүүлэх.
6. НҮБ-ын Удирдлагын баг гүйлгээний зардлыг аль болох бууруулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх.

### Ач холбогдлын дараалал доогуур зөвлөмжүүд:

1. НҮБ-ын Удирдлагын баг нь НҮБ-ын суурин бус агентлагуудыг НҮБТХХАХ-ний үйл явцад татан оролцуулах таатай орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд эдгээр агентлагууд НҮБ-ын ХАХ-ний үйл ажиллагаанд тасралтгүй оролцох
2. НҮБ-ын Удирдлагын баг нь НҮБ-ын мэдээлэл харилцаа, хэвлэлийн бүлгээр дамжуулан нэгдмэл байдлаар харилцах ёстой бөгөөд дотооддоо энэ бүлэг болон Үр дүнгийн, сэдэвчилсэн бүлгүүд хоорондоо илүү амьд холбоотой байх.



## НҮБХТХ ХШҮ-ний хүрээ -- 2020 оны эцсийн үзүүлэлтүүдийн одоогийн ахиц

(Өөрөөр заагаагүй бол шалгуур үзүүлэлтүүдийн одоогийн ахицын эх сурвалж нь Монгол дахь НҮБ-ын ажлын үр дүнгийн тайлан, 2017-2020 юм)

Үзүүлэлтийн хүснэгт:

зорилтод хүрсэн/өссөн
  өөрчлөлтгүй
  буурсан
  мэдээлэл байхгүй

#	Үзүүлэлт	Ангилал
1	1.1.1 ХХ-ийн ялгаруулалтыг ВАУ-ийн хэмжээнээс бууруулах	
2	1.1.2 Үндэсний эрчим хүчний тогтолцоонд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлэх	
3	1.1.3 Ойн талбай, мянган гагаар (нийт газар нутагт эзлэх хувиар)	
4	1.1.4 Хамгаалалттай бүсүүд, мянган га (ТХГ-ын нийт газар нутагт эзлэх хувиар)	
5	1.2 Эдийн засгийг төрөлжүүлэх хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилт – ДНБ-нд үйлдвэрлэлийн нэмүү өртгийн (ҮНӨ, MVA) эзлэх хувь	
6	1.3 Гамшгийн үр дагавар- ДНБ-нд гамшгаас үүдэлтэй эдийн засгийн шууд хохирлын хэмжээ	
7	1.4.1 Ядуурлын доод түвшнөөс доогуур амьжиргаатай хүмүүсийн хувь (хот/хөдөө, хүүхдүүд)	
8	1.4.2 Ажилгүйдлийн хувь (хүйсээр задарснаар)	
9	2.1.1 Сайжруулсан усны эх үүсвэрийг ашиглаж буй хүн амын хувь	(зөвхөн үндэсний зорилт)
10	2.1.2 Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж буй хүн амын хувь	
11	2.2.1.1 Нийгмийн эрүүл мэндийн даатгалд хамруулах (газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн үзүүлэлт болон агуулгаар задарсан)	
12	2.2.1.2 Үр шимийн хамруулалтын шинжилгээ (жендэр, хот /хөдөө, газар зүйн байршил болон нийгэм эдийн засгийн үзүүлэлтээр)	
13	2.2.2.1 Жирэмсний хугацаанд үзлэгт 6-гаас доошгүй удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь	
14	2.2.2.2 15-24 насны 10000 иргэнд тэмбүүгээр өвчилсөн түвшин	
15	2.2.2.3 40-өөс дээш насны иргэдийг шижин (диабет), цусны даралтны үзлэгт хамруулсан хувь	
16	2.2.2.4 Өсвөр үеийн эмэгтэйчүүдийн төрөлтийн хувь (15-19 нас) 1000 хүнд	
17	2.2.3.1 НҮБХТХ-г хэрэгжүүлэх хугацаанд шинэ болон шинэчилсэн эрүүл мэндийн үндэсний бодлого, стратеги, төлөвлөгөөний тоо	
18	2.2.3.2 Бүсийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх стратегийг баталсан аймаг, дүүргийн тоо	
19	2.2.4.1 Нас баралтын түвшинг өвчин тус бүрээр гаргах (жендэр, хот /хөдөө, газар зүйн байршлын үзүүлэлтээр)	
20	2.2.4.2 15-аас 60-н насны хооронд нас барах магадлал (жендэр, 1000 хүн тутамд)	
21	2.3.1 Хамгийн ядуу бүлгийн хүүхдүүдийн бага болон дунд боловсролд хамрагдаж буй түвшин	
22	2.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдсан хувь	
23	2.3.3 Хамгийн ядуу бүлгийн 5-аас доош насны хүүхдүүдийн эрүүл мэнд, сургалт, сэтгэл-нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хувь	
24	2.3.4 Хамгийн ядуу бүлгийн 36-39 сартай хүүхдүүдийн бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдсан хувь	
25	2.3.5 4, 8 дугаар ангийн хүүхдийн тоо, шинжлэх ухааны хичээлийн сурлагын үзүүлэлт	
26	2.4.1 Нийгмийн даатгалд хувь нэмэр оруулж байгаа эдийн засгийн идэвхтэй хүн амын хувь	
27	2.4.2 ДНБ-нд төрийн нийгмийн хамгааллын зардлын эзлэх хувь	
28	2.5.1 5-аас доош насны хүүхдийн өсөлтийн хоцролт	
29	2.5.2 Илүүдэл жинтэй 13-17 насны сурагчдын хувь	
30	3.1.1 Хүн бүрийн эрхийг хамгаалан дээдлэх, наад захын эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ХЭТБ-ын илтгэл болон НҮБ-ын олон улсын гэрээ, конвенцуудын / ЭАБХУОУК, ЭЗСНОУП болон бусад/-ийн Зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал	
31	3.1.2 Бүх төрлийн алагчлалын эсрэг (ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТ) хууль тогтоомж баталж хэрэгжүүлэх	
32	3.1.3 Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн түвшин (ЭОЭХ)	(суурь үзүүлэлтийг 2017 онд тодорхойлсон)
33	3.2.1 Их хурал, засгийн газар, орон нутгийн төлөөлөгчдийн хурал, захиргаанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (ТХЗ, 5.5.1)	(төрийн нарийн бичиг болон орон нутгийн засаг даргаас бусад)
34	3.3.1 УИХ-ын сонгуульд залуучуудын оролцоо	
35	3.3.2 Иргэний оролцоо	